



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2016 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны "Журам батлах тухай" 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" 2015 оны А/22 дугаар тушаалын хавсралт дахь Чилхаасүрэн овогтой Батсуурь-д холбогдох хэсгийн "Калифорнийн их сургууль" гэснийг "Виржиниагийн олон улсын их сургууль" гэж, Чогсом овогтой Мөнхзаяа-д холбогдох хэсгийн "2 жил" гэснийг "3 жил" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР